



ХАЯГ ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХЭРХЭН НӨЛӨӨЛЖ БАЙНА ВЭ?

Илтгэгч: **Ё. Мэндмаа, оюутан**

Manchester College, UK
Манчестерийн Монголчуудийн холбооны удирдагч

Танилцуулга

Хаяг гэдэг нь айл өрх, албан байгууллага, барилга байгууламжийн байрлалыг илэрхийлэх тоон буюу үсгэн илэрхийлэлийн нэгдэл байдаг. Хаягийг засаг захиргааны, нийгмийн үйлчилгээний, худалдаа бизнесийн, газрын зураг, замчлалын зэрэг олон зориулалтаар ашигладаг. Хаягийг шуудангийн илгээмж, захидал, нэрийн хуудас, албан бичиг, иргэний үнэмлэх дээрээс бид алхам дутамдаа харж болно. Бид өдөр тутмын амьдралдаа хаягийг хэрэглэдэг мөртлөө хэрэгцээг нь тэр болгон мэддэггүй. Бидний хэрэглэж байгаа хаяг та бидний амьдарч ажиллаж байгаа барилга байгууламжийн дугаар нэр, гудамж, талбай, дүүрэг, хот, улсын нэрээс бүрддэг.

Стандартын дагуу хийгдсэн хаягийн самбар хийж, байрлуулахүг орхигдсон хийгддэг боловч хангалтгүйгээс гудамж, талбайн нэршлийг иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд тодорхой мэддэггүй. Үүнээс үүдэн барилга байгууламжийн хаяг дугаарыг стандартын дагуу хийж байрлуулах шаардлага тавигдаж байна. Монгол улсын нийгэм эдийн засгийн байдлаас шалтгаалан Улаанбаатар хотын хүн амын төвлөрөл, нягтрал ихсэж, эдийн засгийн хөгжил, зах зээлийн үйл ажиллагаатай холбогдуулан барилга байгууламжийн тоо, гудамж талбай, зам тээврийн үйл ажиллагаа ергэжиж байгаа бөгөөд эдгээрийг зөв зохион байгуулалтанд оруулах нь зүйтэй юм.

Хаягжилтын өнөөгийн байдал

Нүүдэлчин соёл иргэншилтэй манай улсын хувьд хаяг бүртгэлийн асуудлыг шийдвэрлэх нь түвэгтэй байж болох ч Нийслэл Улаанбаатар хот байгуулагдаад өдгөө 370-н жил болжээ. Хаягжилтын асуудлаар олон ажил хийгддэг ч хаягийн талаарх ард иргэдийн ойлголт тааруухан хэвээр байна. Хэн нэгэн хүн хаяг асуувал байшин барилга, дэлгүүр хоршоогоор баримжаалан заана. Хэн ч тэр газрыг ямар гудамжинд байдгийг мэдэхгүй. Мэддэг ч нэрийг нь ашиглаж заншаагүй байдаг. Манай улсын нийт хүн амын 56,5 хувь нь хотод, 43,5 хувь нь хөдөөд амьдарч байна. 1990 ээд оноос эхэлсэн их нүүдлийн улмаас иргэдийн шилжилт хөдөлгөөн эмх замбараагүй болж, хотын захын гэр хорооллын хаягжилт ойлгомжгүй, гудамж талбайн нэр, барилга байгууламжийн байршлын төлөвлөлт, зохион байгуулалт алдагдсан. Нийслэлд шинээр газар эзэмшигчид, барилга орон сууц барьж буй компаниуд хашаагаа барихдаа ямар ч гудамж, орц гарцгүйгээр хийдэг.

Улаанбаатар хотын хэмжээнд 48.0 сая төгрөгийн ертөгтэй 11.200 айлын хашааны хаалганы дугаарын самбар, гэр хорооллын 628 гудамжны нэрийн хаягийн самбар, гэр хорооллын 514 гудамжны дугаарын самбарыг үйлдвэрлэж дүүргүүдийн Тохижилт, үйлчилгээний хэлтсүүдэд хүлээлгэн өгсөн байна. Нийслэлийн статистикийн газар, дүүргүүдийн Тохижилт, үйлчилгээний хэлтэстэй хамтран ажиллаж гудамж, талбай, барилга, байгууламжийн хаягжилтын дэлгэрэнгүй судалгааг гаргажээ. 2007, 2008 онд шинээр нэрлэгдсэн 50 гудамжинд нийт 1072 хаягийн самбар хийж, байрлуулах ажлыг зохион байгуулсан байна. Энэ ажилд нийтдээ 50.0 сая төгрөг зарцуулжээ.

Монгол улсын шуудангийн үйлчилгээг 2010 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөөг 2003 онд Дэд Бүтцийн Яам, Монгол Шуудан ХХК хамтран боловсруулсан бөгөөд хийгдсэн төлөвлөгөөний 11 тэргүүлэх чиглэлийн төслийн нэг нь “Хаягжуулалт” төсөл юм. Уг төслүүдийг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Шуудангийн Салбарын Бодлогын Баримт Бичгийг боловсруулсан байдаг.

Монгол улсын засгийн газрын тогтоолын хэдэн оны хэддүгээр тогтоол 2.4.24-т “Орон зайн мэдээллийн санд тулгуурласан зөөлөн дэд бүтцийн (хаягжуулалт, кодчиллол: бар код, зип код гэх мэт) бий болгож төрийн үйлчилгээг шинэ шатанд гарган үр ашгийг дээшлүүлнэ” гэжээ.

Мөн Монгол улсын засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх, улс орны хэмжээнд нэгдмэл кодчлолыг бий болгож, мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлэх, гудамж, талбай, албан байгууллага, айл өрх бүрийг хаягжуулж шуудангийн бүсийн тогтолцоонд шилжүүлэх бүх шатны шуудан хүргэлтийн тогтолцоог боловсронгуй болгох зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Зам Тээвэр, Аялал Жуулчлалын бичихгүй сайдын 2005 оны 18 тоот тушаалаар ЗИП код(бүсчлэлийн нэгдсэн код)-ыг боловсруулсан. Зам Тээвэр, Аялал Жуулчлалын Яам, Мэдээлэл Харилцаа Холбоо Технологийн газар, Харилцаа Холбооны Зохицуулах Хороо, Газрын Харилцаа, Геодези, Зураг Зүйн газар, Нийслэлийн хот байгуулалт, Төлөвлөлийн газар зэрэг байгууллагууд хамтран уг кодыг боловсруулсан.




Зип кодыг нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх, зорилгоор "Бүсчлэлийн нэгдсэн код"-ын Мэдээллийн нэгдсэн сан бий болгох зорилгоор www.zipcode.mn вэб сайт хийгдээд байгаа. Энэ код нь дараах асуудлуудыг шийдвэрлэснээрээ урьд хэрэглэгдэж байсан кодоос давуу талтай юм. Үүнд:

- Хотын захирагчийн албанаас гаргасан хаягийн журмыг алдагдуулахгүй байх
- Хотын хэтийн төлөвлөлтөөр цаашид гарах өөрчлөлтүүдэд өртөж, тухайн хаягийн хэсгийн код хөдлөхгүй байх
- Монгол Улсын засаг захиргааны кодтой уялдуулах
- Монгол Улсын засаг захиргааны хуваарь өөрчлөгдөхөд хөдөлгөөн орохгүй буюу өөрчлөхөд хялбар өөрөөр хэлбэл кодын зохицуулалт хийх нөөцтэй байх
- Хэрэглэгчдэд ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байх
- Тухайн хаягийн хэсгийн газар зүйн байршлыг тодорхой хэмжээгээр тодорхойлох боломжтой байх.

Шуудангийн илгээмжийн хаягт эзний хаягийг үсгээр бичдэг боловч бүсчлэлийн кодыг хэрэглэснээр:

- Хаягаа алдаатай бичсэн байсан ч кодоо зөв бичсэн тохиолдолд таны шуудангийн илгээмж төөрөхгүй
- Шуудангийн ялгалтын ажиллагаанд нэвтэрсэн технологи учраас цаг алдахгүй хурдан хугацаанд хүргэх боломжийг бүрдүүлэх
- Иргэний бүртгэл мэдээлэл, нийгмийн даатгал, татвар болон банкны үйлчилгээг авахад хаягаа зөв тодорхойлсноор ямар нэгэн будлиангүйгээр үйчлүүлэх зэрэг давуу талтай.

Бүсчлэлийн нэгдсэн код нь 5 оронтой байх ба дараах форматтай.

Угтвар код	Хэсгийн код	
 А	 3 орон хаягийн бүсийн дугаар В ₁ В ₂ В ₃	 1 орон хаягийн блок доторхи хүргэлтийн хэсэг В ₄
1 орон	4 орон	

Жишээ:

13010 гэсэн код нь:

Угтвар код А – 1- Улаанбаатар хот

Эхний 2 орон АВ1 - 3- Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг

Сүүлийн 4 орон В1В2В3В4 - 3010- Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн хаягийн бүс болох Бага хуралдай

21011 гэсэн код нь:

Угтвар код А - 2 - Зүүн бүс

Эхний 2 орон АВ1 - 21- Зүүн бүс, Дорнод аймаг

Сүүлийн 4 орон 1В2В3В4 - 1010- Дорнод аймгийн зүүн зах, Халх гол сум

Сүүлийн 4 орон 1В2В3В4 - 1011- Халх гол сумын зүүн зах, Сүмбэр баг гэх мэтээр тайлбарлагдана.

Шуудангийн нэгдсэн кодын 1-р орон нь засаг захиргааны нэгжийн кодын эхний орон бөгөөд засаг захиргааны нэгжийн кодын эхний орныг Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан Монгол улсын нийт 4 бүсэд хувааж, баруунаас зүүн тийш тэгш тоогоор дугаарлах зарчмаар зохиосон ба сондгой тоог нөөц кодоод үлдээсэн байдаг.

Монгол Улсын бүсийн код:

Бүсийн дугаар	Бүсийн нэр
1	Улаанбаатар хотын бүс
2	Зүүн бүс
4	Төвийн бүс
6	Хангайн бүс
8	Баруун бүс

Эмх замбараагүй байрласан объектуудыг цэгцэнд нь оруулах ажил хийгдэж эхэлжээ. Нийслэл хотын хэмжээнд зөвшөөрөлгүй барьсан гараж, ТҮЦ нийтийн эзэмшлийн зам талбайг хаасан хашаа, хайс нийт 270 гаруй байгааг 90 хоногийн дотор зайлуулах ажлыг Нийслэлийн Дүүргүүдийн Газрын Алба, Мэргэжлийн Хяналтын Алба, Онцгой Байдлын Ерөнхий Газрын хэлтсүүдтэй хамтран хийж эхэлжээ. "Хашаа" нэгдсэн арга хэмжээ эхэлснээс хойш Сүхбаатар дүүрэгт 32 гараж 2 хашаа, Чингэлтэй дүүрэгт 19 хашаа хайс,

Баянзүрх дүүрэгт нийтийн эзэмшлийн талбайд барьсан 7 гараж, мөн орц, гарцыг хаасан 10 хашаа 2 хайсыг буулгажээ.

Хаягжилтын асуудалд олон нийтийн мэдээллийн хэрэгслэлүүд ч анхаарал тавьж эхэлжээ. Ард иргэдэд гудамж, талбайн нэрийг таниулж, хэрэглэж хэвшүүлэх зорилгоор C1 телевиз “Өглөөний эхлэл” нэвтрүүлэг, UBS телевиз, Монголын үндэсний телевизийн “Өглөө” хөтөлбөр, “Жолооны ард сэтгэл амар” FM 96.3 нэвтрүүлгээр бидний сонсож байсан ч хаана байдгийг нь сайн мэддэггүй гудамж талбайг танилцуулж байсан. Энэ мэт нэвтрүүлгүүдийг дэмжиж хамтран ажиллавал үр дүнгээ өгнө. Үндсэний портал гэж олон түмэнд танигдсан www.gogo.mn вэб хуудасны UB тaр хэсгээс хотын гудамж болон гэр хороолол, орон сууц, албан байгууллагуудын хаяг байршлыг харж болно. Энэ нь хаягжилтыг олон нийтэд таниулах, саадгүй хайсан газраа олох боломж олгож байгаа юм.

Хаягжилт муу байгаагаас гардаг үр дагаварууд

Хаягийн эмх замбараагүй, тодорхой бус байдлаас болж олон хүндрэл бэрхшээлүүд гардаг. Яаралтай эмнэлэгийн түргэн тусламж дуудсан тохиолдолд яаралтай очиж чадаагүйгээс эмнэлэгийн тусламж оройтож авах, хүний амь нас эрсдэх, мөн гал команд, цагдаагийн тусламж дуудсан тохиолдолд хоцорч очсоноос их хэмжээний хохирол учрах зэрэг бэрхшээлтэй асуудалтай байнга тулгарсаар байна.

Сонгууль болоход будилаан үүсэх нэг шалтгаан нь хаяг тодорхойгүй айлууд болдог. “Задгай” хэмээх бүртгэл сонгууль будлиантуулах гол хэрэгсэл болсоор ирсэн. Ямар нэг сонгуулийн өмнөхөн сонгуульд зориулж хаягийн бүртгэл, хаягжилтын асуудлыг ярьж эхэлдэг. Хаягийн давхардал их байдгаас сонгогчдийн тоог үнэн зөв гарахад хүндрэлтэй.

Гадаад ба дотоодын иргэд хаягийн талаарх мэдлэг, мэдээлэл муутайгаас очих газраа олохгүй төөрч будилах тохиолдол их гардаг. Манай оронд ирсэн жуулчид улсын маань нийслэл Улаанбаатарт ганцаараа явах нь бүү хэл газрын зураг бариад ч олохгүй газар олон байдаг бололтой.

Шуудангийн үйлчилгээнд хаягийн талаарх ойлголт дутмаг байдлаас шалтгаалан хүргэлтийн маршрутыг нарийвчлан гаргахад хүндрэлтэй байдаг ба шууданг хүргэхэд цаг хугацаа алдаж үргүй зардал гардаг. Хаяг буруу эсвэл дутуу байснаас шууданг хаягт эзэнд хүргэх боломжгүй болдог. Одоогоор гэрээр хүргэлт хийдэг ч ихэнх тохиолдолд хэрэглэгчид шуудангийн салбар дээр биеэр очиж үйлчлүүлэх шаардлагатай байдаг. Айл өрхийг шуудангийн хайрцагтай болгож бүрэн хаягжуулсанаар шууданг гэрийн хаягаар хүргэж иргэд болон албан байгууллагуудын цаг, мөнгийг хэмнэх, чанартай түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх боломжтой.

Хаягийн талаарх ойлголт, хэрэглээг сайжруулсанаар гарах эдийн засгийн ач холбогдол

Хаягийн талаарх ойлголт, хэрэглээ сайжирснаар нийгмийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд ахиц гарч, иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх боломжтой болно. Түргэн тусламж, гал команд, цагдаагийн байгууллагынхан очих газраа хайж цаг хугацаа алдахгүй. Хүний амь нас эрсдэхээс урьдчилан сэргийлж, хохирол учрах явдал буурахаас гадна шатахуун тосны зардал буурч техникийн элэгдэл хорогдол багасна. Сонгуулийн үеэр гардаг будилаан багасч будилаан гарсан сонгуулийг дахин явуулж шийдвэрлэхэд гаргадаг үргүй зардал хэмнэгдэнэ. Гадаад ба дотоодын иргэдэд саад бэрхшээл багатай болно. Мөн бизнесийн байгууллагуудад хаягаар үйлчилгээ үзүүлэх боломж нээгдэх юм. Энэ нь жижиг дунд бизнесийн хөгжилд тодорхой хэмжээгээр түлхэц болно гэсэн үг юм. Хамгийн гол нь иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн системтэй болж шилжилт хөдөлгөөнийг нарийвчлан бүртгэдэг болох юм. Өөрөөр хэлбэл хаягийн давхардал үүсэхгүй байх боломжтой болно.

Шуудангийн байгууллагын хувьд хаягийн талаарх иргэдийн ойлголт сайжирсанаар шуудангийн хүргэлтийн үйлчилгээнд дөхөмтэй болохоос гадна иргэд үйлчлүүлэгчид шуудангийн үйлчилгээг чанар, хүртээмжтэй авах боломжтой болох юм. Мөн шуудангийн компаниудад шинээр үйлчилгээ нэвтрүүлэх боломж нээгдэнэ. Цаашлаад стандартын түвшинд хүрсэн хаягжилттай болох нь манай орны олон улсын харилцааны хөгжилд ч тодорхой хувь нэмэр оруулна.

Хаягийн зөв хэрэглээг иргэдэд хэвшүүлснээр шуудангийн байгууллагын үргүй зардал багасч, хэрэглэгчийн хохирол барагдуулах нөхөн төлбөрт зарцуулдаг зардлыг хэмнэнэ.

Гэрийн хаягаар хүргэлт хийн үйлчилгээнийхээ хүрээг өргөтгөж түүнд тулгуурласан бусад шинэ үйлчилгээг нэвтрүүлж болно. Гэрийн хаягаар хүргэлт хийснээр шуудангийн үйлчилгээний чанарыг сайжруулан, хүртээмжийг нэмэгдүүлэх ба энэ нь шуудангийн үйлчилгээний цэг салбарыг шинээр барьж байгуулахад зарцуулах хөрөнгө оруулалтыг хэмнэнэ. Энэ гарах зардлаа техник технологийн шинэчлэлд зарцуулах боломжтой болно. Шуудангийн солилцоог нэмэгдүүлснээр ашиг орлого нэмэгдэнэ. Гэхдээ хаягийн хэрэглээг хэвшүүлж, хэрэглүүлэхээс гадна айл өрх бүрийг шуудангийн хайрцагтай болгох нь энэ үйлчилгээг нэвтрүүлэх үндэс болно.

Хаягжилтыг сайжруулахад хийх зарим ажил

Хаягийн стандарт, хаягжилтын асуудалыг холбогдох байгууллагууд анхаарч ажиллахаас гадна хаягийн хэрэглээг ард, иргэдэд таниулан сурталчлах ажлыг давхар хийж, энэ талын мэдээллийг хүртээмжтэй болгох нь илүү үр дүнтэй ажил болно.

Гудамж, талбайн нэрсийг олон нийтэд таниулах ажил зохион байгуулах:

- Лавлах, гарын авлага хэвлүүлж хямд үнээр борлуулах, үнэгүй тараах
- Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн сургалтын хөтөлбөрт танин мэдэхүйн чиглэлээр оруулах
- Видео, хичээл хэлбэрээр олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр явуулах

ZIP буюу бүсчлэлийн кодыг хэрэглээнд нэвтрүүлж, хэрэгжүүлэх:

- ZIP буюу бүсчлэлийн кодын вэб хуудсыг улам боловсронгуй болгох
- Лавлах, товхимол хийж хямд үнээр худалдах буюу үнэгүй тараах
- Шуудангийн болон бусад байгууллагуудад кодыг хэрэглэж хэвшүүлэх
- Шуудангийн болон бусад байгууллагын ажилчдыг сургалтанд хамруулах
- Оюутан залуусын дунд Бүсчлэлийн кодыг сайжруулах, хэрэгжүүлэх сэдвээр тэмцээн уралдаан зохион байгуулах

Бүсчлэлийн кодыг таниулж хэрэгжүүлэх ажлыг хийж хаягжилтыг сайжруулахад зориулсан сан бий болгон төсөл хөтөлбөр хэрэгжүүлж болно. Дотоод нөөц бололцоогоо ашиглан, ард иргэдийнхээ оролцоог нэмэгдүүлэн ажиллах бололцоотой.

Хаягжилтын талаарх олон улсын туршлага

Хаягжилтын боловсронгуй хэлбэрийг ZIP CODE эсвэл POST CODE гэж ойлгож болно. Post code-г Герман улс анх 1941 онд нэвтрүүлж байсан бол түүний дараа Англи улс 1959, Америк улс 1963 онд нэвтрүүлж байжээ. Уг кодыг анх шуудангийн ялгалтыг хялбар болгох зорилгоор ашиглаж байсан бол одоо энэ кодыг мэдээллийн бааз хэлбэрээр ашиглах болжээ. 2005 онд Дэлхийн Шуудан Холбооны 190 гишүүн орны 117 нь кодын системтэй болсон байсан ба улс орон бүр өөрсдийн онцлогт тохирсон кодыг зохиож ашигласаар иржээ. Герман улс одоо хэрэглэж байгаа таван оронтой кодоо 1993 оны 7 сарын 1-д шинэчилэн хийсэн байна. Анхны нэгдсэн кодын номоо 2005 онд гаргаж байжээ.

Шуудангийн энэ кодын систем гарахаас өмнө Азид тэр дундаа Японд ихэнх барилга байгууламжууд дугаар хаяггүй харин газар усны эсвэл хотын зах, дэлгүүр болон хүмүүсийн нэрлэж заншсан нэрээр нэрлэгддэг байжээ. Шуудангийн систем бий болсноор шууданг хүргэх зорилгоор барилга байшинг дугаарлах шаардлагатай болжээ. Европ, Америкийн ихэнх оронд гудамжаа дугаарлахдаа тэгш сондгойгоор нь ялгадаг.

Англи, Ирландын жижиг хотуудад байшинг дугаарлахаасаа илүү нэрлэх нь элбэг тохиолддог. Жишээлбэл байшин байрлаж буй гудамжийг уг байшингийн нэрээр нэрлэдэг.

Дүгнэлт

Хүн төрөлхтөн хаягийг олон арван жилийн турш янз бүрийн хэлбэртэйгээр өөр өөр зориулалтаар ашиглаж хөгжүүлсээр иржээ. Дэлхийн улс орнууд ч өөрсдийн онцлог нөхцөлд тохирсон хаягийн системтэй түүнийгээ боловсронгуй болгож бүх талаар ашиглаж байгаа.

Нэг стандартын хаягтай, бүсчлэлийн кодыг бүрэн хэрэглэдэг болсноор нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төрийн болоод төрийн бус байгууллагуудын үр ашиггүй зардал багасч хамгийн чухал нь цаг хугацааг хэмнэнэ. Бизнесийн байгууллагууд үйлчилгээнийхээ хүрээг тэлж, ашиг орлогоо нэмэгдүүлэх өргөн боломж нээгдэнэ. Өөрөөр хэлбэл хаягийг баталгаажуулж мэдээллийн системийн баазтай болох нь улс орны нийгэм, эдийн засгийн онцгой ач холбогдолтой юм.

Нийслэлийн засаг даргын 2003 оны 113 дугаар тогтоолоор “Гудамж, талбайн нэр, барилга хашааны дугаарын самбар, түүнийг байрлуулахад тавих ерөнхий шаардлага” гэсэн стандартыг баталсан. (MNS 5283-2003). Хэдийгээр нэгдсэн стандарттай боловч түүний хэрэгжүүлэлт шаардлагатай хэмжээнд хүрч чадахгүй байна.

Төрөөс нийгэмд үзүүлж байгаа аливаа үйлчилгээг цаг алдалгүй, чирэгдэл багатай, найдвартай хүргэх нь төр нийгмийн байнгын тогтвортой холбоог бий болгоход чухал ач холбогдолтой. Энэ үүргийг нийгмийн аль ч давхарга, засаг захиргааны нэгж, иргэн бүрт хүртээмжтэйгээр төрийн өөрийнх нь байгууллага гүйцэтгэж чаддаг. Энэ салбарын нэг бол яах аргагүй шуудангийн салбар мөн.

Шуудангийн салбар нь зөвхөн харилцаа холбооны төдийгүй Монгол улсын нийгмийн харилцааны анхдагч салбаруудын нэг бөгөөд төр улсынхаа хөгжил, нийгмийн харилцааны өөрчлөлт шинэчлэлтийн дагуу төр, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг, түүнийг хэрэгжүүлэх арга ажиллагаа нь улам боловсронгуй болж хөгжсөөр өнөөг хүрсэн. Гэхдээ төрийг төлөөлж нийгэмд үйлчлэх түүхэн үүрэг нь хэвээр үлдэж, ач холбогдол нь улам өссөөр байгаа. Дэлхийн бусад орнуудын шуудангийн байгууллагуудын нийгэмд эзэлж байгаа байр суурь,

гүйцэтгэж байгаа үүрэг үүнийг бэлхэнээ харуулж байна. Монгол улс нь Дэлхийн шуудангийн нэгдмэл сүлжээний нэгэн хэсгийг бүрдүүлж байдгийн хувьд олон улсын жишигт нийцсэн хаягийн систем, шуудангийн боловсронгуй кодтой болох асуудал зүй ёсоор тавигдаж байна.

ZIP (Zone Improvement Plan) code нь хаягжилтанд гарсан нэгэн томоохон дэвшил юм. Манай орны хувьд өмнө нь зөвхөн Монгол шуудан компаний хэрэгцээний шуудангийн кодтой байсан бол одоо хийгдээд байгаа Бүсчилэлийн нэгдсэн код нь улсын хэмжээнд хэрэглэгдэх мэдээлийн нэгдсэн систем болох юм. Уг кодыг нэвтрүүлж, хэрэглээ болгон хаягжилттай нягт холбож өгснөөр дэлхийн хөгжилтэй орнуудтай хөл нийлүүлэн алхах боломж нэг шатаар ахиж байгаа явдал юм. Хаягжилт сайжруулж, хаягийн хэрэглээг нэмэгдүүлэхэд нүдэнд харагдаж гарт баригдах ашиг байхгүй мэт боловч улс орон, нийгмийн хөгжилд тодорхой ахиц дэвшил гаргадаг. Тиймээс бусад орнуудын туршлагаас судлан өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан хаягийн талаарх иргэд, байгууллагуудын ойлголт, мэдлэгийг сайжруулах нь зөвхөн шуудангийн байгууллага биш нийгмийн өмнө тавигдаж байгаа асуудал болжээ.

Иймд урт богино хугацааны янз бүрийн төлөвлөгөөнүүдийг шат дараатай боловсруулан хэрэгжүүлснээр үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хувьд харилцагчтайгаа нягт холбоотой ажиллаж бизнесээ өргөжүүлнэ. Харин иргэн бүр хаяг гэдэг ойлголтын чухлыг мэдэж хэрэглээ болгоно. Хаягийн системд үндэслэн төр болон байгууллага, иргэд хоорондын бодит холбоо бий болж төрөөс нийгэмд үзүүлэх үйлчилгээг улам ойртуулж, чанартай үйлчилгээ үзүүлэх бололцоотой болно. Ингэснээр ард иргэдийн шууданд итгэх итгэл нэмэгдэж улмаар шуудангийн хөгжилд зохих хэмжээний дэвшил гарах нь дамжиггүй.